

ЭН АР СИ СИ компани Хэрэглэгчийн итгэлийн улирал тутмын судалгааг Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран 2022 оны 12-р сард амжилттай зохион байгууллаа. Судалгаанд Монгол Улсын 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотын 900 гаруй иргэд хамрагдаж, эдийн засгийн өнөөгийн төлөв, ойрын ирээдүйн хандлагын талаар мэдээлэл өгсөн байна.


Хэрэглэгчийн итгэлийн индекс

Монгол Улсын хэрэглэгчдийн эдийн засагт итгэх итгэл 2022 оны 4-р улиралд өмнөх улиралтай адилхан түвшинд байна. Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 66.9 байгаа нь жилийн өмнөхөөс 30.0 пунктээр доогуур байна. 4-р улирлын үзүүлэлтүүдийг өмнөх улиралтай харьцуулан авч үзье. Бизнесийн нөхцөл болон хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдлын

талаарх хэрэглэгчдийн үнэлэмжийг харуулдаг *Өнөөгийн байдлын индекс* энэ улиралд 91.2-оос 70.4 болж эрс буурсан. Харин хэрэглэгчдийн бизнесийн нөхцөл, орлого болон хөдөлмөрийн зах зээлийн ойрын ирээдүйн хүлээлтийг харуулдаг *Ирээдүйн хүлээлтийн индекс* 58.8-аас 65.7 болж өсчээ.

Хэрэглэгчийн Итгэлийн Индекс (2018=100)

Хэрэглэгчийн итгэл 66.9 буюу өмнөх улирлын түвшиндээ боловч жилийн өмнөхөөс 30.0 пунктээр буурсан байна. Энэ улиралд өнөөгийн байдлын үнэлэмж 21 пунктээр буурсан бол ирээдүйн хүлээлт 7 пунктээр өсчээ.



Тайлбар: ХИИ болон түүний бүрэлдэхүүн индексүүдийг улирлын нөлөөгөөр засварлаж, 2018 оны индекстэй харьцуулж тооцсон (Индекс 2018=100).

Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал

Хэрэглэгчдийн эдийн засгийн өнөөгийн байдлын үнэлэмж өмнөх улирлаас буурсан байна. Бизнесийн нөхцлийн талаарх үнэлэмж муудсан. 2.7 хувь нь бизнесийн нөхцөл “сайн” гэж хариулсан нь 2.8 пунктээр бага байна. 69.7 хувь нь бизнесийн нөхцөл “муу” гэж хариулсан бөгөөд энэ нь 3.7 пунктээр өндөр байна. Хэрэглэгчдийн хөдөлмөрийн зах зээлийн үнэлгээ ч мөн мууджээ. 22.7 хувь нь ажлын олдоц “элбэг” гэж хариулсан нь өмнөх улирлаас 3.7 пунктээр бага, 41.7 хувь нь ажил олоход “хэцүү” гэж хариулсан нь өмнөх улирлаас 5.4 пунктээр өндөр байна.

Эдийн засгийн ойрын ирээдүйн төлөв

Хэрэглэгчдийн эдийн засгийн ойрын ирээдүйн талаарх хүлээлт эрс муудахад бизнесийн нөхцөл муудна гэсэн хүлээлт нөлөөлсөн байна. Хэрэглэгчдийн 11.7 хувь нь ойрын ирээдүйд бизнесийн нөхцөл “сайн” байна гэж хариулсан нь өмнөх улирлаас 0.2 пунктээр бага, 37.5 хувь нь бизнесийн нөхцөл “муу” байна хариулсан нь өмнөх улирлаас 2.6 пунктээр өндөр байна. Харин орлого болон ажлын олдоцны хувьд хэрэглэгчид тодорхойгүй байдалтай байна. Хэрэглэгчдийн 14.7 хувь нь орлого өснө гэж үзсэн нь 2.0 пунктээр өндөр байгаа боловч, 21.2 хувь нь орлого буурна гэж үзсэн нь 5.7 пунктээр өндөр байна. 19.4 хувь нь ажлын олдоц сайжирна гэж үзсэн нь 10.6 пунктээр бага байгаа бол 22.2 хувь нь муудна гэж үзсэн нь 1.0 пунктээр өндөр байна.

ХИИ-д нөлөөлж буй хүчин зүйлс

	2021.IV	2022.III	2022.IV	Жилийн өөрчлөлт	Улирлын өөрчлөлт
Өнөөгийн байдал					
<i>Бизнесийн нөхцөл</i>					
Сайн	4.4	5.5	2.7	-1.7	-2.8
Хэвийн	31.7	33.5	26.9		
Муу	63.5	60.1	69.7	0.9	3.7
<i>Ажлын олдоц</i>					
Сайн	21.7	26.4	22.7	1.6	-3.7
Хэвийн	41.3	36.1	34.3		
Муу	36.1	36.3	41.7	5.7	5.4
Ойрын ирээдүй					
<i>Бизнесийн нөхцөл</i>					
Сайн	24.2	11.9	11.7	-12.5	-0.2
Хэвийн	49.8	49.1	45.8		
Муу	24.0	34.9	37.5	13.5	2.6
<i>Ажлын олдоц</i>					
Сайн	21.1	8.7	19.4	-1.7	10.6
Хэвийн	63.8	68.0	55.4		
Муу	14.0	21.1	22.2	8.1	1.0
<i>Орлого</i>					
Сайн	21.6	12.7	14.7	-6.9	2.0
Хэвийн	65.8	70.9	62.6		
Муу	12.1	15.5	21.2	9.1	5.7


Хэрэглэгчийн итгэл ба эдийн засгийн өсөлт

Хэрэглэгчийн итгэлийн индексийг олон улс орнууд үнэлж мэдээлдэг бөгөөд тухайн орны эдийн засгийн төлөв байдлыг сайн харуулж чаддаг гэж үздэг. Монгол Улсад ч ХИИ-ийг улирлаар үнэлж эхэлснээс хойшхи динамикийг харвал эдийн засгийн өсөлттэй ойрхон хамаа-

ралтай байна. ХИИ-ийн индекс хэвийн буюу 100 ба түүнээс дээш утгатай улирлуудад эдийн засаг дунджаар 6.1 хувийн өсөлттэй байсан бол ХИИ 100-гаас бага утгатай улирлуудад эдийн засаг 2.6 хувийн өсөлттэй байна.

Хэрэглэгчийн итгэл ба эдийн засгийн өсөлт

Хэрэглэгчийн итгэлийн индекс эдийн засгийн өсөлттэй ойрхон хамааралтай байна



Эх үүсвэр: YСХ-ны 1212.mn мэдээллийн сайт. Тайлбар: Эдийн засгийн өсөлтийн мэдээллийг YСХ-ны цахим хуудаснаас авсан.



2022 оны дөрөвдүгээр улиралд хэрэглэгчдийн эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлэмж өмнөх улирлаас буурсан ч ойрын ирээдүйн хүлээлт өмнөх улирлаас бага зэрэг өндөр байна. Ажлын олдоц сайжирна гэсэн хүлээлт хэрэглэгчдийн ойрын ирээдүйн хүлээлтийг өсгөсөн байна.


Инфляцын хүлээлт

Ирэх 6 сарын хугацаанд үнийн түвшин өснө гэсэн хүлээлттэй иргэдийн хувь 70, ирэх нэг жилийн хугацаанд үнийн түвшин өснө гэсэн хүлээлттэй иргэдийн хувь 58 байна. Хэрэглэгчид инфляцын түвшинг ирэх 6 сар болон нэг жилийн хугацаанд харгалзан 9.5 болон 10.7 хувь байна гэсэн хүлээлттэй байна. Хүлээгдэж буй инфляцын ойрын 6 сар болон жилийн дараах түвшингүүд өмнөх улиралтай харьцуулахад буурсан байна.

Эндээс үзвэл иргэдийн дийлэнх нь үнийн түвшин өснө гэж үзэж байна. Гуравдугаар улиралд иргэдийн инфляцын хүлээлт өсөх хандлагатай байсан бол энэ улиралд инфляцын хүлээгдэж буй утга эргээд буурсан байна. Энэ улиралд инфляцын талаарх тодорхой бус байдал эрс өссөн. Хөдөө амьдардаг хэрэглэгчдийн ирэх нэг жилийн хугацааны үнийн түвшний хүлээлт Улаанбаатар хотод амьдардаг хэрэглэгчидтэй ойролцоо түвшинд байна. Хотод жилийн хүлээгдэж буй инфляц 10.7 хувь байгаа бол хөдөө 11.0 хувь гэж гарлаа. 6 сарын инфляцын хүлээлт хөдөөний хэрэглэгчдийн дунд хотынхоос арай өндөр байна.

Үнийн хүлээлт, ирэх нэг жилийн хугацаанд

Ирэх нэг жилийн хугацааны инфляцын хүлээлт 10.7% (Хөдөө-11%, Хот-10.6%) байгаа нь өмнөх улирлаас 3.2 пунктээр бага, өмнөх оны мөн үетэй ойролцоо байна.



Эх сурвалж: ҮСХ-ны 1212.mn мэдээллийн сайт

